



ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2026 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 07

Өмнөдэлгэр сум

Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтэд
хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2019 оны 228 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 9.4 дэх заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Аравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх бүтээн байгуулалтын ажилд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Э.Заяабаяр	Чандган багийн засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Д.Баярхүү	Татварын улсын байцаагч
Гишүүд:	Ц.Оюун-Эрдэнэ	Биеийн тамирын арга зүйч
	Г.Алтантуяа	ИТХ-ын Төлөөлөгч
	С.Тэгшжаргал	ИТХ-ын Төлөөлөгч

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, чанар, худалдан авах үйл ажиллагаанд хяналт тавьж тайланг хагас бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж иргэдэд мэдээлэл хүргэн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Э.Заяабаяр)-т даалгасугай.

3.Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 24 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ

D.disc /alban bichig/ ITH togtool

232600119